ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧ ТӨХК-ИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код:** САГ-2018/14/-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:
Цахим хуудас: www.audit.mn
Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885
Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn
Аудитор Н.Нямдаваа
Утас: 261740
Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн
Захирал С.Тунгалаг
Утас: 70001778
Цахим хаяг: tungalag.s@imkaudit.mn
Чанарын хяналтын мэргэжилтэн: С.Сожидмаа
Утас 70001778
Цахим хаяг: sojidmaa.s@imkaudit.mn
Аудитор: Д.Буянравжих
Утас: 70001778
Цахим хаяг: buyanravjikh.d@imkaudit.mn

Улаанбаатар хот

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ........ 0
2 Аудитын тайлан ........ 1
2.1 Оршил ........ 1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 2
2.5 Дотоод хяналт ........ 3
2.6 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 3
2.7 Шилэн дансны мэдээлэл ........ 3
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар ........ 4
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл ........ 4
*2.9.1 Залруулсан алдааны талаар* ........ 4
*2.9.2 Зөвлөмжийн талаар* ........ 7
*2.9.3 Албан шаардлагын талаар* ........ 8
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд ........ 10
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл ........ 10
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 11
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: ........ 11
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 12
3 Менежментийн захидал ........ 13
Асуудал 1: Бараа материалын талаар ........ 14
Асуудал 2: Эзэмшигчийн өмчийн талаар ........ 15
Асуудал 3: Авлага, өр төлбөрийн талаар ........ 16
Асуудал 4: Цалин хөлсний талаар ........ 17
4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 18
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 18
4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан ........ 19
4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 1
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 1
4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт ........ 2


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# 1 Аудитын гэрчилгээ

БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ
ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ Р.НЯМТУУЛ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Үүрэг, хариуцлага**

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–д заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн захирал Р.Нямтуул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв**.**

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн зорилтот түвшний биелэлт, үндсэн хөрөнгийн элэгдэл, санхүүгийн програм хангамжийн талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай,Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн удирдлага жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн жилийн эцсийн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 14-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 14-нд эцэслэн баталгаажуулж, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, "Ихмонгол хөлөг Аудит" ХХК-ийн аудитор Д.Буянравжих, аудиторын туслах Т.Оюун, гэрээт ажилтан Н.Болормаа, аудиторын туслах К.Баасанхүрэл, аудитын менежер Г.Ариунбат нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 60 дугаар албан бичгээр "Ихмонгол хөлөг Аудит" ХХК-д ирүүлсэн байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Нягтлан бодох бүртгэлийн, Компанийн, Харилцаа холбооны, Эрчим хүчний, Сэргээгдэх эрчим хүчний тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 217 дугаар тогтоолоор баталсан байна.

Импортын эрчим хүчний үнэ буурсантай холбоотойгоор хэмнэгдэж буй цахилгааны зардлаас, шаардлагатай их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгууллалтын арга хэмжээгээр хийх ажил болон салбарын цалинжих доод жишигт нийцүүлж, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авахаар 2017 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт оруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 9 дүгээр сарын 12-ны өрийн 375 дугаар тогтоолоор тодотгон батлуулсан байна.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь баталсан гэрээ, зорилтот түвшний үзүүлэлтийг хангах биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, улсын төсвийн татаас, өөрийн үйл ажиллагааны орлогоор зардлаа санхүүжүүлэн ажилладаг.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн эрхэм зорилго нь: Баруун бүс нутгийг импортын болон дотоодын эх үүсгүүрийн чанартай эрчим хүчээр найдвартай хангаж, хэрэглэгчдийг дээдэлсэн соёлтой үйлчилгээ үзүүлэх явдал юм.

**Үйл ажиллагааны стратегийн зорилт**:

Байгальд ээлтэй экологийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасралтгүй хангах зорилттой.

**Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:**

Дотоодын эрчим хүчний эх үүсвэрээр баруун бүс нутгийг хангах, цахилгаан дамжуулах төвийн бүсийн системтэй зэрэгцэн ажиллах нэгдсэн системд шилжихэд оршино.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

## 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 13 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 41 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Апекс” програм хангамжаар бэлтгэсэн байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “хэвийн” гэж үзлээ.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны 01 дүгээр сарын 04- ний өдрийн 06 дугаар тушаалаар дотоод хяналт хариуцсан ажилтнаар А.Цэнд-Аюушийг томилсон байна.

Дотоод хяналтын ажилтан нь 3 охин компанийн 2016 оны жилийн, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмчийн хөрөнгөөрхи худалдан авалт, хадаглалт, хамгаалалт, зарцуулалт, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд хөтлөлтөнд батлагдсан удирдамжийн дагуу дотоод хяналтыг хийж 15 зөвлөмж өгч ажилласан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2015, 2016 оны удирдлага, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах тухай 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 622 дугаар тогтоолыг хүргүүлж, хэрэгжилтийг 2018 оны 1 дүгээр улиралд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлэхийг даалгасан байна.

## 2.6 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот төвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 375 дугаар тогтоолоор 12,592.0 сая төгрөгийн орлого, 23,415.8 сая төгрөгийн зардалтай, 8,600.0 сая төгрөгийн улсын төсвийн татаас авч 2,454.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь тайлант онд 22,004.6 сая төгрөгийн нийт орлоготой, 26,206.2 сая төгрөгийн зардалтай, 4,201.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 8,4 сая төгрөгийн орлогын албан татвар төлсөн байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад, оруулах шаардлагатай 14 төрлийн мэдээллийг бүрэн байршуулсан байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 41 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### *2.9.1 Залруулсан алдааны талаар*

***Дөргөний УЦС ХХК***

- Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 63.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ хэсэгт тайлагнасан байна.

Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 5 дугаар 3 дахь заалтыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын тодруулга ба толилуулаг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Дуусаагүй үйлдвэрлэлийн 2.0 сая төгрөгийн зардлыг Санхүүгийн байдлын тайланд урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэж заасныг мөрдөөгүй байна.

Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 7-д “тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж хүлээн зөвшөөрөхөөс өмнө төлбөрийг урьдчилж төлсөн зардлыг)даатгал, түрээс гм( санхүүгийн тайлангийн хөрөнгийн зүйл ангид хмараарууулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ”, 6.1-д “дуусаагүй үйлдвэрлэл: үйлдвэрлэж дуусаагүй бүтэгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг” гэснийг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын тодруулга ба толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

- Худалдан авсан 54.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ худалдан авалтанд төлсөн 5.5 сая төгрөгийн НӨАТ-ыг капиталжуулаагүй, НӨАТ-ын буцаан авалтаар бүртгэсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 1.5-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй" гэж заасныг мөрдөөгүй байна.

- Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-д шилжүүлсэн үндсэн хөрөнгөнд ноогдох 0.2 төгрөгийн НӨАТ-ийн дүнгээр авлагыг нэмэгдүүлээгүй байна .

- Үндсэн хөрөнгийн өртөгт оруулаагүй хөрөнгийн дүнд 0.1 сая төгрөгийн элэгдлийг байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүтгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Ажиллагсадын хандив, тусламж, татварын алданги торгуулийн 53.3 сая төгрөгийн зардлыг Ерөнхий удирдлагын зардлаар тайлагнасан байна.

Энэ нь 2012 оны 77 дугаар тушаалын 10-д “Ерөнхий удирдлагын зардлыг ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр,хураамжийн,томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний сургалтын, сонин сэтгүүл захилагын, даатгалын цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгаалалтын, цэвэрлэгээ үйлчилгээний,тээврийн, шатахууны, хүлээн авалтын зардлууд, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй, судалгааны болон хөгжүүлэлтийн зардал болон бусад зардал гэж тодруулна” гэж заасныг, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, үнэн зөв байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Увс ЦТС ХХК***

- Цахилгааны орлогын 0 үлдэгдэлтэй байх төгрөгийн кассанд 4.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу ХААН банкин дахь 5800193799 дугаар дансанд 2017 оны 12 сарын 31 нээрхи үлдэгдлийг харилцах тушаагаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Нягтлан бодох бүртгэлд 7.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан боловч санхүүгийн тайлангийн тодруулгад 7.2 сая төгрөгөөр буюу 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд данснаас хассан хөрөнгийн 0.3 сая төгрөгийн элэгдлийг тусгаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Мөнгөн гүйлгээний тайланд биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө гэж 48.2 сая төгрөгөөр тайлагнасан боловч нягтлан бодох бүртгэлээс 1.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Худалдан авсан 62.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ худалдан авалтанд төлсөн 6.3 сая төгрөгийн НӨАТ-ыг капиталжуулаагүй, НӨАТ-ын буцаан авалтаар бүртгэсэн байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 1.5-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй" гэж заасныг мөрдөөгүй байна.

- Тайлант хугацаанд худалдан авсан 1.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансад бүртгэсэн.

Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Нийт 2 байгууллагын 0.6 сая төгрөгийг авлагын үлдэгдлийг өглөгийн дансанд, 3 байгууллагын 0.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг авлагын дансанд тус тус сөрөг утгатай бичсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Ховд ЦТС ХХК***

- Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд хүлээн авсан 1.0 сая төгрөгийн хүүгийн орлогыг , 0.5 сая төгрөгөөр дутуу буюу 0.5 сая төгрөгөөр тайлагнаж, Биет бус хөрөнгө худалдсан авахад төлсөн 14.9 сая төгрөгийг 9.9 сая төгрөгөөр дутуу буюу 5.0 сая төгрөгөөр тус тус тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

- Худалдан авсан 117.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ худалдан авалтанд төлсөн 11.1 сая төгрөгийн НӨАТ-ыг капиталжуулаагүй, НӨАТ-ын буцаан авалтаар бүртгэсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 1.5-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй" гэж заасныг мөрдөөгүй байна.

- Үндсэн хөрөнгийн өртөгт оруулаагүй хөрөнгийн дүнд 0.5 сая төгрөгийн элэгдлийг байгуулаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

- Хандив, буцалтгүй тусламж, шүүхийн тэмдэгтийн хураамж зэрэг 17.7 сая төгрөгийн зардлыг Ерөнхий удирдлагын зардлаар тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

- Ажиллагсадын хувийн хэрэглээнд худалдан авсан 1.1 сая төгрөгийн бараа материалын 0.1 сая төгрөгийн НӨАТ-ын буцаалтыг татварын тайланд НӨАТ-ын өглөгийг бууруулж тайлагнасан байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 14.6.2-д “хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг хасахгүй" заалтыг зөрчсөн байна

- Хандив, буцалтгүй тусламж, шүүхийн тэмдэгтийн хураамж зэрэг 17.7 сая төгрөгийн зардлыг Ерөнхий удирдлагын зардлаар тайлагнасан байна.

Энэ нь ажиллагсадын хувийн хэрэглээнд худалдан авсан 1.1 сая төгрөгийн бараа материалын 0.1 сая төгрөгийн НӨАТ-ын буцаалтыг татварын тайланд НӨАТ-ын өглөгийг бууруулж тайлагнасан нь НӨАТ-ын тухай хуулийн 14.6.2-т “хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг хасахгүй" гэж заасныг зөрчсөн байна.

- Алданги торгуулийн орлогын 62.1 сая төгрөгөөс 5.6 сая төгрөгийн НӨАТ-ын өглөгийг тооцоолж тайлагнаагүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 7-р зүйлийн "НӨАТ ногдох бараа, ажил, үйлчилгээ", 7.2.13-д "Бусдын буруутай үйл ажиллагааны улмаас хүү, торгууль, алданги авах" гэснийг зөрчсөн байна.

- Худалдан авсан 162.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд 133.9 сая төгрөгөөр буюу 28.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 5 дугаар бүлгийн 2.1-д "Үндсэн хөрөнгө,биет бус хөрөнгө, урт хугацаат хөрөнгө олж эзэмшиэхэд төлсөн мөнгө" гэж заасныг болон санхүүгийн тайлагналын толилуулга ба илчлэл батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***ББЭХС ТӨХК***

- Татварын улсын байцаагчийн 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 150021004 дугаар актаар НӨАТ-аар 240.9 сая төгрөгийн нөхөн татвар,120.5 сая төгрөгийн торгууль, 0.7 сая төгрөгийн хүү торгууль нийт 362.1 сая төгрөгийн төлбөр тавигдаж ,хүү торгуульд төлсөн 121.2 сая төгрөг, нөхөн татварт төлсөн 230.0 сая төгрөг бүгд 351.2 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 20-д Бусад зардал" Орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад зардлын дүнг тодруулна. Тухайлбал алданги, торгууль, найдваргүй авлагын зардал" гэж заасныг,санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ТУЗ-ын гишүүн 13 хүнд олгосон 38.9 сая төгрөгийн цалингаас 0.7 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг илүү тооцсон байна.

Энэ нь "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт 84.0 мянган төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэн заалтыг баримтлаагүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Нягтлан бодох бүртгэлд залруулж тайлагнав.

### ***2.9.2 Зөвлөмжийн талаар***

***Увс ЦТС ХХК***

- Тэсийн хар үзүүр багт хийсэн 04-ын цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр ашиглалтанд оруулсан 408.4 сая төгрөгийн шугамыг эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн байна.

Энэ нь сангийн сайдын 77 дугаар  Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаал, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үнэ төлбөргүй авсан хөрөнгийг орлогоор бүртгэхээр заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийн хангахгүй байна.

- Айл өрхүүдээс авах авлагыг оны эхнээс 67.8 сая төгрөгөөр бууруулсан боловч, нийт 436.2 сая төгрөгийн авлага, 683.2 саятөгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Нийт авлагын 92.8 хувь буюу 404.6 сая төгрөгийг айл өрхүүдээс авах авлага ээлж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг, санхүүгийн тайлагналын их бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

- Нийт 7 байгууллагаас хэд хэдэн нэр төрлийн 247.0 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ1 удаа үнийн санал авч худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-д "техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Ховд ЦТС ХХК***

- Санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн бусад хэсэгт 68.4 сая төгрөгийг тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 17-д "Эздийн өмчийн бусад хэсэг"-ийн бүрэлдэхүүн тус бүр )тухайлбал, ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актаур олз, гарз, санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз,мөнгөн гүйлгээний хейдж дэхь хейджийн хэрэглүүрээс үүссэн олз,гарз( гэж заасныг мөрдөөгүй ,санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***ББЭХС ТӨХК***

- Нийт 5 байгууллагын 576.7 сая төгрөгийн авлагаас 3 байгууллагын 555.0 сая төгрөгийг авлагыг, 5 байгууллагад төлөх 2,022.7 сая төгрөгийн өр төлбөрөөс 5 байгууллагын 2,022.7 сая төгрөгийн өр төлбөрийг тус тус тооцоо нийлсэн актаар баталгаажуулж 2,559.4 сая төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8 д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх"гэж заасныг ,санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Програмын тохируулга буруу хийгдснээс ажилласан хоног дутуу хүмүүст сарын үндсэн цалингаас ажил хавсарсны нэмэгдлийг тооцож 1.1 сая төгрөгийг илүү олгосон нь санхүүгийн тайалагналын үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөвлөмж өгөх.

### *2.9.3 Албан шаардлагын талаар*

- ББЭХС ТӨХК-ийн ХААН банк дахь 5830081966 дугаар хүүгийн дансыг хаасан баримтыг шалгахад 2013-2016 оны 11 дүгээр сар хүртэл ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Цэвээн овогтой Насанжаргал, гүйцэтгэх захиралаар ажиллаж байсан Цэгмэд овогтой Наранчанга нар нь уг дансыг захиран зарцуулж 1,2 дугаар гарын үсэг зурж байхдаа компанийн нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнахгүйгээр нийт 24.8 сая төгрөгийг хувийн харилцах дансандаа шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ",14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасныг мөрдөөгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг, оршин байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Холбогдох хүмүүсийг хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлага бичих.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрчим хүчний зохицуулагчдын зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 144, 145, 146, 147, 148 дугаар тогтоолуудыг 6 дугаар сарын 01-нээс, 2017 оны 9 дүгээр сарын 7-ны 221, 222 дугаар тогтоолуудыг 9-р сарын 1-нээс, 2017 оны 9 сарын 28-ний 254, 274, 275 дугаар тогтоолуудыг 9 сарын 1-нээс тус тус мөрдөхөөр эрчим хүчний үнэ тарифыг өөрчилсөн.

ОХУ-ын импортын эрчим хүчний үнэ 3,33 рублиэс 2017 оны 4 сарын 1-нд 2,85 рубль, 2017 оны 7 сарын 1-нээс 2,77 рубль болон 2 удаа буурсан.

